

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны 05-р сарын 16-ны өдөр

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Дамжуулах сүлжээ ашиглалтын газар,
Дамжуулах сүлжээний хэлтэс, Сүлжээ
удирдлагын төв

Албан тушаалын нэр:

Диспетчер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Инженер

Ажлын цаг:

Сар бүрийн батлагдсан ээлжийн
хуваарийн дагуу ажиллана.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Үндсэн сүлжээний тоног төхөөрөмж болон шилэн кабелийн системийн өдөр тутмын ашиглалт, түүний байнгын найдвартай ажиллагааг хяналт, удирдлагаар хангаж ажиллах.

Албан тушаалын зорилт:

- Хот хооронд болон улс хоорондын үндсэн сүлжээний дамжуулах тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай, тогтвортой ажиллагааг хангах;
- Дамжуулах сүлжээний дагуух аймаг орон нутаг, харьяа станцуудыг технологийн удирдлагаар хангаж, гэмтэл саатлыг тодорхойлох чадвартай байх;
- Удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангаж, ажлаа тайлагнах, танилцуулах мөн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журмыг мөрдөн ажиллах;
- Харилцагч байгууллагын ээлжийн инженер техникийн ажилтнуудтай харилцааны өндөр соёлтой харилцаж өдөр тутмын ажиллагааны байдал, сүлжээнд гарсан гэмтлийн шалтгаан нөхцөл цаг хугацааг тохирч ажиллах, ажлын бус цагаар захиалгат ажил хүлээн авч, харьяа газарт хүргэж, операторуудтай хамтран ажиллах.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг |
|---------------------------|--|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Ээлжийн хугацаанд /08:30-16:30, 16:30-08:30/ хот хооронд болон улс хоорондын дамжуулах сүлжээний хэвийн найдвартай ажиллагаанд хяналт тавьж, шуурхай арга хэмжээ авч, аймаг газар, өөрийн харьяа сайтуудын инженер техникийн ажилтнууд ба ээлжийн инженерийг удирдлагаар хангаж ажиллах; 2. Ээлжийн инженер ажил эхлэхээс өмнө хяналтын системээс үндсэн сүлжээний дохио дохиоллуудыг шалгаж ээлж солилцох протоколд хөтөлнө. Мөн техникийн баримт бичиг, схем заавар, хэмжүүрийн багаж, холболт шалгалтын кабель шнурууд, ажлын багаж, техникийн өрөөнүүдийн түлхүүр, аж ахуйн зүйлсийг нэг бүрчлэн бүртгэж, бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээж авах; 3. Хэрэглээний программ хангамж болон оффис хэрэглээний тоног төхөөрөмжүүд дээр ажилладаг байх; 4. Анхан шатны бүртгэлүүдийг журмын дагуу бүрэн хөтлөх. |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Хот хооронд болон улс хоорондын үндсэн сүлжээний шилэн кабелийн трасс, шилэн кабелийн тойруу сүлжээг бүрэн мэддэг байх гэмтэл саатлын үед системийг нөөц сүлжээ рүү шилжүүлэх чадвар эзэмшсэн байх; 2. Орон нутгийн шилэн кабелийн хүлээн авах түвшний мэдээллийг SDH систем дээр сар бүр, DWDM систем дээр 14 хоног бүр авч хөтлөлт хийж, мэдээлэл өгөх; 3. Хот хооронд болон улс хоорондын дамжуулах сүлжээнд ашиглагдаж байгаа SDH /S385, S380, S330, S325, S200/, DWDM /M900, ZXONE9700, Optix OSN8800/, радио релейний /ZXNW NR8120/, PTN6120 тоног төхөөрөмжийн хүчин чадал, ажиллагааны зарчмыг бүрэн судалж мэдэх; 4. Дамжуулах системүүдийн удирдлага хяналтын програм хангамж дээр ажиллах чадвар эзэмших, хяналт дээр өгөгдсөн тэжээлийн болон дохио дохиоллыг шалгаж анализ хийж арилгах арга хэмжээ авах, мөн хэмжилт /E1, дата, 10G урсгалаар тест хийх/ шалгалт тохируулга хийх; 5. Дамжуулах сүлжээгээр дамжиж байгаа суваг, урсгалын холболт, зохион байгуулалтыг мэддэг байх; 6. Дамжуулах сүлжээний тоног төхөөрөмжийн зай тэжээлд хяналт тавьж зай тэжээлээс шалтгаалсан гэмтэл саатлаас урьдчилан сэргийлэх; 7. Аймаг орон нутаг, өөрийн харьяа сайтууд гарсан гэмтэл саатлын үед орон нутгийн инженер техникийн ажилтан нарыг үнэн зөв бодит мэдээлэл, удирдлагаар хангаж гэмтэл саатлыг бүрэн засварлуулах; Үндсэн сүлжээний төвийн системийн инженерийн заавраар тухайн гэмтлийг засварлах ур чадвар эзэмшсэн байх; 8. Системийн инженерийн заавраар тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, хэмжилт тохируулгыг тогтмол батлагдсан графикын дагуу хийж, ажлын үр дүн болон төхөөрөмжинд орсон өөрчлөлтийг техникийн паспортонд тухай бүрт нь тэмдэглэх. |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг /цаг үеийн онцгой нөхцөл байдлын үед/ цаг тухайд биелүүлж тэднийг чиг үүргийн дагуу үнэн зөв, бодит мэдээллээр хангах; 2. Ээлжийн мэдээг гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлэх. |

| | |
|--|---|
| 4 дүгээр зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй болон галын аюулгүй ажиллагааг технологийн дагуу ханган, дүрэм зааврыг мөрдөж ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу тогтмол хэрэглэж осол зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллах; 2. Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар ХАБЭА-н ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах; 3. Байгууллагад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлж, өөрийн хариуцсан ажлын хүрээнд компанийн ХАБЭА-н дүрэм, Галын аюулын байдлын дүрмийн хэрэгжилтийг хангаж ХАБЭА-н гурван шатны хяналтын I шатны хяналтыг хийж, үр дүнг мэдээлэх; 4. Ажлын байран дахь үйл ажиллагааны явцад хүний амь нас эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах; 5. Компанийн бизнесийн болон сүлжээний нууцлалыг хамгаалах, хадгалах. |
| 5 дугаар зорилтын хүрээнд | <ol style="list-style-type: none"> 1. Гэмтэл саатлын үед “Гэмтэл саатлын үед ажиллах журам”-ын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллах; 2. Гэмтэл саатлын үед харилцагч байгууллагуудын тасарсан урсгалын судалгааг үнэн зөв гаргаж инженерт хүргэх; 3. Гадны оператор компаниуд болон суваг түрээслэгч байгууллагын инженер техникийн ажилтнууд компанийн техникийн болон зай тэжээлийн өрөө, В1 давхрын шилэн кабелийн оруулгын өрөөнд орж ажиллах хүсэлтийг хүлээн авч бүртгэлжүүлээд хянан зөвшөөрч, аймаг, дүүргийн газрууд руу нэвтрэх хүсэлтийг илгээнэ; 4. Улс хоорондын болон дотоодын харилцагч байгууллагуудаас ирсэн албан хүсэлт болон мэйл хаягийн дагуу дамжуулах сүлжээнд шалгалт хийх; 5. Ахлах инженер болон системийн инженерийн зөвшөөрлийн дагуу систем дээр шинээр урсгал үүсгэж, урсгалын багтаамжийг нэмэгдүүлж/бууруул, устгана; 6. Ажлын бус цагаар захиалгат ажлыг хүлээн авч, харъяа газар хүргүүлж, операторуудтай хамтран ажиллах; 7. Нийслэлийн шуурхай удирдлагын төвөөс ирсэн гомдол саналыг хүлээн авч, зохих арга хэмжээг авч ажиллах; 8. Компанийн бизнесийн болон сүлжээний нууцлалыг хамгаалах, хадгалах. |
| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/. |
| Мэргэшил | Мэргэшлийн сургалтад хамрагдсан бол давуу тал болно. |
| Туршлага | Мэргэжлийн салбартаа 3-аас доошгүй жил ажилласан. |



| | |
|-----------|---|
| Ур чадвар | Холбооны онолын болон программ хангамжийн өндөр мэдлэгтэй; Хот хоорондын сүлжээний зохион байгуулалт, хэмжилт тохируулга засварын ажил хийх чадвартай; Англи хэлний зохих мэдлэгтэй байх; Удирдан зохион байгуулах ур чадвартай, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай, эерэг хандлагатай; |
|-----------|---|

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ахлах инженер

| | |
|--|--|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: 1. Компанийн нийт ажилтнууд 2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд |
|--|--|

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| БОЛОВСРУУЛСАН: | БАТАЛСАН: |
|---|--|
| <p>ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА</p>  <p>А.ДАМДИН</p> <p>2023 оны 05-р сарын 16-ны өдөр</p> | <p>ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p>(тамга/тэмдэг)</p>  <p>Д.МЯНГАНБААТАР</p> <p>2023 оны 05-р сарын 16-ны өдөр</p> |